



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/56

Амардалай

┌ Зуны цагийн хуваарьт шилжүүлэх тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "б", "ж", Хог хаягдлын тухай хуулийн 9.4.1, 9.4.12, Аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Суманд худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжийн ажиллах цагийн хуваарийг өглөө 08.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл зуны цагийн хуваарьт шилжүүлсүгэй.

Хоёр: Нийтийг хамарсан их цэвэрлэгээний үед худалдаа үйлчилгээ явуулахыг түр хугацаагаар зогсоож, өөрийн аж ахуйн нэгжийн ойр орчмоос 50 метр хүртэлх газрыг цэвэрлэж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аж ахуйн нэгжийн дарга, удирдлагуудад даалгасугай.

Гурав: Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/, хэсгийн цагдаа /Б.Насанжаргал/, Байгаль орчны мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч /Б.Энхдэлгэр/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ЦОЛМОНБААТАР

4880100130